

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8 Аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн	6
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	12
3.1 Орлогын данстай холбоотой асуудал.....	12
3.2 Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.3 Зардлын данстай холбоотой асуудал.....	13
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТББ	Төрийн бус байгууллага



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН
ТАНАА

2020.04.24 № 1325
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон УСНББОУС, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн данс бүртгэлийн бичилтийг зөв хийх, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж ажиллах талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 05-аас 2020 оны 4 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Д.Болор-Эрдэнэ гүйцэтгэв.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1359 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд оршино.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах;
- Хөрөнгө оруулагч, харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах;
- Банкнаас бусад санхүүгийн зах зээл болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагууд, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд хяналт шалгалт хийх;
- Бодлого зохицуулалтын орчныг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” батлагдсан;
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” батлагдсан;
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” батлагдсан;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашинны эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашинны сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталжээ.

2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын шинэчлэлт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны дотоод хяналтын хэлтэс 2018 оны худалдан авах ажиллагааны тайланд хяналт шалгалт хийж, цаашид худалдан авах ажиллагааг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар 7 зөвлөмж өгч, хэрэгжилтийг 80 хувиар үнэлсэн, мөн Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газраас 2019 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд 87 хувь буюу “Хангалттай” үнэлгээ өгч хүргүүлсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Санхүүгийн зохицуулах хорооны бэлтгэсэн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 5,614.4 сая төгрөгийн 2 хувь буюу 112.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 54.8 сая, эцсийн үлдэгдэл 14.5 сая төгрөг болж, 40.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	54.8	14.5	(40.3)
Дүн	54.8	14.5	(40.3)

Эх сурвалж: СЗХ-ны 2019 оны санхүүгийн тайлан

Банканд байршиж буй 14.5 сая төгрөг нь ахмадын сангийн төрийн сангийн үлдэгдэл байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 70.5 сая, эцсийн үлдэгдэл 77.3 сая төгрөг болж, 6.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.3	2.6	0.3
Татаас, санхүүжилтийн авлага	64.1	61.0	(3.1)
Бусад авлага	4.1	13.7	9.6
Дүн	70.5	77.3	6.8

Эх сурвалж: СЗХ-ны 2019 оны санхүүгийн тайлан

Нийт авлагын 78.9 хувь буюу 61.0 сая төгрөг нь Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-аас гадаад томилолт, сургалт, хэлэлцүүлэг, санхүүгийн зах зээлийн хэрэглэгчийн итгэлийн судалгааны зардлын үлдэгдэл 46.9 сая, тайлант оны эцэст Төрийн сангийн дансанд төвлөрсөн тэмдэгтийн хураамжийн орлого 13.9 сая төгрөгийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулан бүртгэсэн байна.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 1,044.0 сая, эцсийн үлдэгдэл 310.6 сая төгрөг болж, 733.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	44.3	191.5	147.2
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	15.2	-	(15.2)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	984.5	119.1	(865.4)
Дүн	1,044.0	310.6	(733.4)

Эх сурвалж: СЗХ-ны 2019 оны санхүүгийн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2018 - 2019 онд үүссэн 310.6 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

Урьдчилгаа дансанд 2018 онд үүссэн:

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 201 дүгээр тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нэг жилийн хугацаанд хэрэгжих “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, санхүүгийн салбарын цахим мэдээллийн системийг шинэчлэх ажлын хүрээнд эрсдэлийн үнэлгээний систем хөгжүүлэх” гэрээт ажлын гүйцэтгэлээр урьдчилгаа данснаас хасаж хөрөнгөд бүртгэсэн, программын шалгалт тохируулгын ажил хийгдэж байгаатай холбоотойгоор гэрээг сунгасан дуусаагүй ажлын 119.1 сая төгрөгийн урьдчилгаа;
- Монголын үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбоо, Харилцаа хамтын ажиллагааг дэмжигч сэтгүүлчдийн холбоо, Санхүү, бизнесийн эрх зүйн судалгааны хүрээлэн ТББ-тай хийсэн судалгааны ажил, үйлчилгээний гэрээний дуусаагүй ажлын үлдэгдэл 13.2 сая төгрөг .

Урьдчилгаа дансанд 2019 онд үүссэн:

- “Монхурд” ХХК-иар гүйцэтгүүлэх урсгал засварын ажлын 39.2 сая төгрөгийн урьдчилгаа;
- Монголын үндэсний статистикийн хороотой хийсэн гэрээт ажлын 60.5 сая төгрөгийн урьдчилгаа;
- Ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх 13 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээний 118.6 сая төгрөгийн урьдчилгаа байна.

2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 149.6 сая, эцсийн үлдэгдэл 120.9 сая төгрөг болж, 28.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Бичиг хэргийн материал	46.4	27.0	(19.4)
Аж ахуйн материал	48.5	48.7	0.2
Бусад хангамжийн материал	54.7	45.2	(9.5)
Дүн	149.6	120.9	(28.7)

Эх сурвалж: СЗХ-ны 2019 оны санхүүгийн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авсан 150.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 179.0 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Нийт үлдэгдлийн 77.7 хувийг албан ажлын хэрэгцээнд ашиглагдаж байгаа хангамжийн материал эзэлж байна.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 476.6 сая, эцсийн үлдэгдэл 1,253.4 сая төгрөг болж, 776.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Авто-тээврийн хэрэгсэл	26.3	11.9	(14.4)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	185.3	575.0	389.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	121.1	181.6	60.5
Дуусаагүй барилга, байгууламж	56.8	56.8	-
Программ хангамж	18.4	378.0	359.6
Бусад биет бус хөрөнгө	68.7	50.1	(18.6)
Дүн	476.6	1,253.4	776.8

Эх сурвалж: СЗХ-ны 2019 оны санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгө тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 37.6 сая, 2018 оны урьдчилж төлсөн худалдан авах ажиллагааны гүйцэтгэлээр ТӨБЗГ-ын 2020 оны А-1/644 дүгээр “Үндсэн хөрөнгө дансанд бүртгэх” шийдвэрийн дагуу 863.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 21.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны тооцсон элэгдэл 137.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 2008 онд гүйцэтгүүлсэн ашиглах нь тодорхойгүй 56.8 сая төгрөгийн барилгын ажлын зураг бүртгэлтэй байна.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 32.8 сая, эцсийн үлдэгдэл 2.3 сая төгрөг болж, 30.5 сая төгрөгийн өр төлбөр барагдсан байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	32.8	2.3	(30.5)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.3	0.3	-
Байгууллагад төлөх өглөг	31.1	0.9	(30.2)
Хувь хүмүүст төлөх өглөг	1.4	1.1	(0.3)
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-
Нийт дүн	32.8	2.3	(30.5)

Эх сурвалж: СЗХ-ны 2019 оны санхүүгийн тайлан

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,762.8 сая, эцсийн үлдэгдэл 1,774.4 сая төгрөг болж, 11.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	1,762.8	1,774.4	(11.6)
Өмч: -Төрийн өмч	590.2	590.2	-
Хуримтлагдсан үр дүн	1,172.6	1,184.2	(11.6)
Дүн	1,762.8	1,774.4	(11.6)

Эх сурвалж: СЗХ-ны 2019 оны санхүүгийн тайлан

Засгийн газрын хувь оролцооны дансанд Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 111 дүгээр тушаалын дагуу 2018 онд төвлөрүүлсэн дансны үлдэгдэл 30.0 сая төгрөг шилжүүлснийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр бүртгэж, мөн тайлант үеийн үр дүн 18.4 сая төгрөгийн алдагдал нөлөөлсөн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд гүйцэтгэлээр 1,351.1 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт, 50.3 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 3,762.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас, 2,740.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,022.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвөөс 2,736.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 3.5 сая төгрөг дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,871.1 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг 849.1 сая төгрөгөөр давуулсан нь Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 211 дүгээр тогтоолоор “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ыг шинэчлэн баталж үйлчилгээний хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт 3,564.8 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 197.4 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.

Батлагдсан төсвөөс материаллаг дүнтэй илүү, дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 156.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлууд хийгдээгүй;
- Гадаад албан томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 47.9 сая төгрөг илүү зарцуулсан нь батлагдсан төсвийг зохих журмын дагуу төсөвт зохицуулалт хийж, зардал хооронд гүйлгэн зарцуулсан холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 5 арга хэмжээнд 289.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 273.2 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 207.0 сая, 2018 оны татан төвлөрүүлсэн эхний үлдэгдэл 34.0 сая, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 459.6 сая нийт 700.6 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн цалин болон нэмэгдэл урамшилд 191.7 сая, ажил олгогчоос нийгмийн даатгал шимтгэлд 18.3 сая, хангамж, бараа материалын зардалд 1.3 сая, эд хогшил, урсгал

засварын зардалд 39.2 сая, томилолтын зардалд 173.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 97.6 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 128.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 50.3 сая төгрөгийг төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Аудитаар нийт 1,171.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,107.5 сая төгрөгийн алдааг залруулж, 63.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өглөө. Тухайлбал:

1. Урьдчилж төлсөн зардалд 996.6 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийг хүлээн авсан ч, хөрөнгийг холбогдох дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийв.

2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 59.6 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулсан.

Залруулагдаагүй 63.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 6 зөвлөмжийг менежментийн захидалд өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын Дээд Шүүхийн 2016 оны 724, 2017 оны 1409 дүгээр тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооноос нийт 923.4 сая төгрөгийг "Ариг гал" ХК-д олгохоор шийдвэрлэсэн ч уг төлбөрийг барагдуулах эх үүсвэргүй байгаа нь анхаарал татахуйц асуудал байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Санхүүгийн зохицуулах хороо нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 155 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 18.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, нийт 6 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, журмын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Залруулагдаагүй 63.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 112.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага, шинж чанарын хувьд материаллаг илэрхийлэгдээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлтийг өгч байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан асуудлыг цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөдөггүй /2017 онд 630.4 сая, 2018 онд 1,158.8 сая, 2019 онд 459.5 сая төгрөгөөр давсан/ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд "Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага", Сангийн сайдын 2017 оны "Журам батлах тухай" 216 дугаар тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөдөггүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны орлогыг бодитой, үндэслэл, судалгаатай төлөвлөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.2 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт:

- Ахмадын сангаас 3.5 сая төгрөгөөр тэмцээн уралдаан зохион байгуулж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2017 оны "ахмадын сан байгуулан ажиллуулах журам" 197 дугаар тогтоолын 3.1.8-т "ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх" гэж заасантай нийцээгүй;
- Мэдээлэл технологийн зардлаас 28.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, эдийн засгийн зардлын ангилал зөрчсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн

байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2014 оны 55, 2018 оны 134 дүгээр тушаалд тус тус заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.3 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 76.8 сая төгрөгийн 8084УНН улсын дугаартай Ландкрузер-200 маркийн автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ "Тогтвортой амьжиргаа төсөл-2"-ын нэр дээр бүртгэлтэй, хүлээлцсэн актгүй, гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-т "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгө алдагдах, шамшигдах.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.5 Зардлын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Өмнөх онд урьдчилж төлсөн 132.3 сая төгрөгийн программын хөгжүүлэлт болон ажил үйлчилгээ хийгдэж дуусаагүй, гэрээний хугацааг сунгасан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-т "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Гэрээт ажил цаг хугацаандаа хийгдээгүй байх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажлын явцын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.6 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа харьцуулалтын арга сонгоогүй, шууд 28.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө”, 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Бараа, ажил үйлчилгээний төсөвт өртөгт багтааж, худалдан авах ажиллагааны журмыг сонгох.

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллах.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,318,922.5	523,281.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	54,801.1	14,511.5
33	АВЛАГА	70,525.7	77,276.7
34	УРЬДЧИЛГАА	1,044,012.0	310,570.5
35	БАРАА МАТЕРИАЛ	149,583.7	120,923.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	476,634.8	1,253,420.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	476,634.8	1,253,420.4
39200	Биет хөрөнгө	389,563.4	825,283.7
39300	Биет бус хөрөнгө	87,071.4	428,136.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,795,557.3	1,776,702.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,780.9	2,278.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,780.9	2,278.0
41300	Өглөг	32,780.9	2,278.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,762,776.4	1,774,424.3
51	Засгийн газрын хувь оролцоо	1,762,776.4	1,774,424.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	590,228.9	590,228.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,172,547.5	1,184,195.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,795,557.3	1,776,702.3

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,650,481.4	5,565,247.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	54,454.5	64,211.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	54,454.5	64,211.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,081,545.3	2,557,278.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,081,545.3	2,557,278.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,514,481.6	2,943,757.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,558,536.1	5,583,599.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,558,536.1	5,583,599.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,433,873.6	3,807,979.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,028,242.3	2,186,998.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,133.0	275,629.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,195.5	91,665.0
2104	Хангамж, бараа материалын зардал	71,392.2	80,355.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,493.9	24,324.3
2107	Томилолт, зочны зардал	221,343.6	298,631.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	527,086.2	712,985.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,986.9	137,388.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,124,662.5	1,775,620.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,091,945.2	-18,352.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,448.6	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,090,496.6	-18,352.1

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,679,496.9	5,616,516.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	54,474.5	64,221.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	54,474.5	64,221.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	54,474.5	64,221.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,173,367.6	2,114,839.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,173,367.6	2,114,839.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,451,654.8	3,437,456.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,583,299.1	5,619,207.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,583,299.1	5,619,207.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,405,503.4	3,779,880.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,041,943.0	2,108,601.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,054.1	257,933.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98,195.5	91,665.0
2104	Хангамж, бараа материалын зардал	76,722.9	73,673.4
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	291,624.8	53,554.3
2107	Томилолт, зочны зардал	250,569.3	285,711.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,391,393.9	908,741.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,177,795.7	1,839,327.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	96,197.8	-2,690.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	60,247.7	37,598.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,247.7	37,598.9
2200	Дотоод эх үүсвэрээр	60,247.7	37,598.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-60,247.7	-37,598.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,950.1	-40,289.6
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,851.0	54,801.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,801.1	14,511.5

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	651,103.3	-	651,103.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	651,103.3	-	651,103.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	21,176.5	-	21,176.5
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	1,090,496.6	-	1,090,496.6
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,762,776.4	-	1,762,776.4
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,762,776.4	-	1,762,776.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	30,000.0	-	30,000.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,792,776.4	-	1,792,776.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-18,352.1	-	-18,352.1
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,774,424.3	-	1,774,424.3

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6.1	-6.1	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,762,241.1	3,564,820.3	197,420.8	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,762,241.1	3,564,820.3	197,420.8	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,444,450.0	3,278,539.3	165,910.7	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,916,927.6	1,916,927.6	-	100.0
210101	Үндсэн цалин	1,469,525.8	1,314,788.9	154,736.9	89.5
210102	Нэмэгдэл	170,921.2	376,192.7	-205,271.5	220.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	276,480.6	225,946.0	50,534.6	81.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,616.0	239,616.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	162,938.9	239,616.0	-76,677.1	147.1
210202	Тэтгэмжийн даатгал	19,169.3	-	19,169.3	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,335.4	-	15,335.4	-
210204	Ажилгүйдлийн даатгал	3,833.9	-	3,833.9	-
210205	Эрүүл мэндийн даатгал	38,338.5	-	38,338.5	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,526.0	91,665.0	861.0	99.1
2102	Байрны түрээс	92,526.0	91,665.0	861.0	99.1
2104	Хангамж, бараа материалын зардал	72,654.8	72,654.8	-	100.0
210401	Бичиг хэрэг	26,040.3	29,068.2	-3,027.9	111.6
210402	Тээвэр, шатахуун	14,534.5	14,271.4	263.1	98.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,080.0	26,605.6	5,474.4	82.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,709.6	-2,709.6	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000.0	14,352.3	647.7	95.7
210604	Урсгал засвар	15,000.0	14,352.3	647.7	95.7
2107	Томилолт, зочны зардал	120,101.9	112,202.4	7,899.5	93.4
210701	Гадаад албан томилолт	-	23,808.2	-23,808.2	-
210702	Дотоод албан томилолт	120,101.9	64,335.7	55,766.2	53.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	24,058.5	-24,058.5	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	987,623.7	831,121.2	156,502.5	84.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	690,176.7	652,022.2	38,154.5	94.5
210803	Даатгалын үйлчилгээ	6,288.5	6,288.5	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000.0	798.0	202.0	79.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	128.5	88.0	40.5	68.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	106,200.0	88,716.5	17,483.5	83.5
210807	Газрын төлбөр	530.0	137.3	392.7	25.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	183,300.0	83,070.6	100,229.4	45.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	317,791.1	286,281.0	31,510.1	90.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	279,246.0	279,246.0	-	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	279,246.0	279,246.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,545.1	7,035.0	31,510.1	18.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,345.1	-	31,345.1	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,200.0	7,035.0	165.0	97.7

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,762,241.1	3,564,814.2	197,426.9	94.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,740,241.1	1,693,736.4	1,046,504.7	61.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,740,241.1	1,693,736.4	1,046,504.7	61.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,022,000.0	1,871,077.8	-849,077.8	183.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,022,000.0	1,871,077.8	-849,077.8	183.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	288	288	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	144	144	-	100.0
620001	Удирдах ажилтан	21	21	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	123	123	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	144	144	-	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	132	132	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3	-	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	700,624.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	700,624.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,656.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,673.7
210101	Үндсэн цалин	62,508.7
210104	Урамшуулал	129,165.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,317.6
210201	Тэтгэврийн даатгал	18,317.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,368.6
210401	Бичиг хэрэг	57.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,311.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,202.0
210604	Урсгал засвар	39,202.0
2107	Томиллот, зочны зардал	173,509.4
210701	Гадаад албан томиллот	173,509.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,585.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,585.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,968.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,700.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,700.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,268.2
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	50,268.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	700,624.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	700,624.7
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	700,624.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1.0

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/15/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Санхүүгийн зохицуулах хороо		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөдөггүй. /2017 онд 630.4 сая, 2018 онд 1,158.8 сая, 2019 онд 459.5 сая төгрөгөөр давсан/	-	Зөвлөмж	Ажлын албаны дарга Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга	Т.Жамбаажамц Б.Нансалмаа
2	Ахмадын сангаас 3.5 сая төгрөгөөр тэмцээн уралдаан зохион байгуулж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	3.5	Зөвлөмж	Ажлын албаны дарга Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга	Т.Жамбаажамц Б.Нансалмаа
3	Мэдээлэл технологийн зардлаас 28.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, эдийн засгийн зардлын ангилал зөрчсөн.	28.2	Зөвлөмж	Ажлын албаны дарга Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга	Т.Жамбаажамц Б.Нансалмаа
4	Санхүүгийн тайланд бүртгэлтэй 76.8 сая төгрөгийн 8084УНН улсын дугаартай Ландкрузер-200 маркийн автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ "Тогтвортой амьжиргаа төсөл-2"-ын нэр дээр бүртгэлтэй, хүлээлцсэн актгүй, гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй.	-	Зөвлөмж	Ажлын албаны дарга Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга	Т.Жамбаажамц Б.Нансалмаа
5	Өмнөх онд урьдчилж төлсөн 132.3 сая төгрөгийн программын хөгжүүлэлт болон ажил үйлчилгээ хийгдэж дуусаагүй, гэрээний хугацааг сунгасан.	-	Зөвлөмж	Ажлын албаны дарга Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга	Т.Жамбаажамц Б.Нансалмаа
6	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа харьцуулалтын арга сонгоогүй, шууд 28.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн.	28.0	Зөвлөмж	Ажлын албаны дарга Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга	Т.Жамбаажамц Б.Нансалмаа
Нийт зөрчлийн дүн		63.7			

